

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК



**ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер

шалгаруулалтын

нэр:

Тендер

шалгаруулалтын

дугаар:

"Хөдөлмөр хамгааллын хувцас" худалдан авах

УБЦТС/20240102181

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	1
4. Сонирхогч этгээд, оролцогч	1
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг	2
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл	3
11. Тендерийн иж бүрдэл.....	3
12. Тендерийн жишиг маягтууд	4
13. Хувилбарт санал	4
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг	4
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага	6
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт	6
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт	7
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	7
20. Тендерийн валют.....	8
21. Тендер хүчинтэй байх хугацаа	8
22. Тендерийн баталгаа	8
23. Тендер баталгаажуулах, илгээх	8
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа	9
25. Тендерийн талаар тодруулга авах	9
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	9
27. Тендерийг үнэлэх	9
28. Арифметик алдааг залруулах.....	9
29. Оролцогчид давуу эрх олгох.....	9
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт	10
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	10
32. Тендерийг эрэмбэлэх.....	10
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	10
34. Мэдэгдэл хүргүүлэх	10
35. Гүйцэтгэлийн баталгаа.....	10
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	10

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.	Тендериин цар хүрээ	1.1.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
1.2.		1.2.	Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
1.3.		1.3.	Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
1.4.		1.4.	Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг	2.1.	Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3.	Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж	3.1.	Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4.	Худалдан авах ажиллагааны цахим систем	4.1.	Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх-/ээр зохион байгуулна.
5.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	5.1.	Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
5.2.		5.2.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 ¹ , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
6.	Сонирхогч оролцогч	6.1.	Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
 - 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
 - 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
 - 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
 - 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
 - 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
 - 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
 - Б.АГУУЛГА**
 - 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
 - I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
 - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
 - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
 - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
 - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
 - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
 - 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
 - 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13. Тендерийн иж бүрдэл**

- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**
- 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.**
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.**
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.
- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

- 17.9.** Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10.** Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11.** ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12.** Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1.** Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2.** Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3.** Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4.** Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1.** Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагaa ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.
- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 21.10. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 21.11. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 21.12. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 21.13. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 21.14. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.15. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 21.16. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 21.17. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 21.18. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

		31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
		31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт		32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох	үнийг	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
34. Тендерийг эрэмбэлэх		34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
35. Оролцогчийн чадавхыг магадлах	дахин	35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ		
36. Шийдвэр хүргүүлэх		36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
37. Гүйцэтгэлийн баталгаа		37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах		38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хөдөлмөр хамгааллын хувцас
ТШЗ 1.1	Тендерийн зарлалын дугаар: УБЦТС/20240102181
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц 1. Ажлын зуны хувцас Багц 2. Ажлын өвлийн хувцас Багц 3. Танхимины дүрэмт хувцас
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Тийм Зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Батлагдсан төсөөт өртөг: 397,890,650 (гурван зуун ерэн долоон сая найман зуун ерэн мянга зургаан зуун тавь) төгрөг Багц 1. 132,924,000 төгрөг Багц 2. 239,327,000 төгрөг Багц 3. 25,639,650 төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ Төрийн Өмчит Хувьцаат Компанийн Хангамж үйлчилгээний хэлтсийн Хангамжийн алба. Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, УБЦТС ТӨХК-ийн төв байр. Утасны дугаар: 11-342420-158 Цахим шуудангийн хаяг: www.tog.mn
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: Үгүй
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй.
ТШЗ 17.4	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: Тийм. Тендер нээх хугацаанаас өмнө нийлүүлэх санал болгож буй даавуу материалын загварыг ирүүлнэ. Загварын материалыг "Ноос ноолуурын сорилтын төв"-өөр шинжлүүлж туршилтын бичгийн хамт ирүүлэх. Ижил төстэй хувьцасны загварыг хамт ирүүлж болно. Гэрээний байгуулсан тохиолдолд ирүүлсэн загварын дагуу барааг нийлүүлж байгаад захиалагч хяналт тавина.
ТШЗ 17.6	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: Шаардана.
ТШЗ 18.1	Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: Шаардахгүй. Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: Шаардлагатай. 2022, 2023 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөөт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг нийлүүлсэн байх шаардлагатай.

	<p>Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, хүлээлгэж өгсөн акт, гэрээ дүгнэсэн протокол ирүүлнэ. (Ижил төстэй ажилд ажлын гутал, хувцас, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл нийлүүлсэн туршлагыг тооцино.)</p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: Шаардлагагүй.</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай. ❖ Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. ❖ Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх. ❖ Тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлт хийхээс 3-аас доошгүй хоногийн өмнө нэзвтрэн орж шүүхийн тусгай архивын лавлагаа авах хүсэлтийг илгээх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл хянан үзэж лавлагаа цахимаар илгээдэг болохыг анхаарна уу. ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ. <p>Жич: Дээрх 2 лавлагаа авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p>												
ТШЗ 18.2	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: Шаардана. Дотоодын үйлдвэрлэлийн барааг нотлох тохирлын гэрчилгээг ирүүлэх.</p>												
ТШЗ 19.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: Тийм.</p> <ol style="list-style-type: none"> 1. Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлогын хэмжээ нь багц тус бүрийн батлагдсан төсөөт өртгийн 80 хувь болон түүнээс багагүй байна. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Багц тус бүрийн батлагдсан төсөөт өртгийн 80 хувиас багагүй байна. 3. Оролцгийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан ирүүлнэ. 												
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”</p> <ol style="list-style-type: none"> 1. 2022, 2023 онуудад ижил төрлийн бараа болон түүнтэй дүйцэхүүц бараа, ажлын гутал, хувцас, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл нийлүүлсэн туршлагыг харуулсан жагсаалтыг Маягт 3 маягтаар доорх зааврын дагуу ирүүлнэ. Үүнд: <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center; padding: 5px;">Гэрээний нэр</th> <th style="text-align: center; padding: 5px;">Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</th> <th style="text-align: center; padding: 5px;">Төсөөт өртөг</th> <th style="text-align: center; padding: 5px;">Хугацаа /эхэлсэн, дууссан/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center; height: 40px;"></td> </tr> <tr> <td style="text-align: center; height: 40px;"></td> </tr> </tbody> </table>	Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөөт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/								
Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөөт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/										

	<p>Дээрх жагсаалтаар ирүүлсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээллийг ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл буюу Маягт 5 маягтаар гаргаж ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 2. Байгууллагын танилцуулга, тоног төхөөрөмжийн мэдээллийг ирүүлэх. Байгууллагын байршил, мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж ирүүлэх. 3. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ. 4. Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 5. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 6. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 7. Захиалагч гэрээ байгуулах үед нийлүүлэх барааны техникийн нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг 20 хувиар өөрчлөх эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай албан мэдэгдэл ирүүлнэ. 8. Чанарын баталгаа 06 сар ба тус хугацаанд гарсан гэмтэл saat, гологдол, бусад асуудлыг яаж шийдвэрлэх талаар албан мэдэгдлээр ирүүлнэ. 9. Санал болгож бараа бүтээгдэхүүний даавуу, материал нь “Ноос ноолуурын сорилтын төв”-өөр шинжлүүлсэн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх.
ТШЗ 21.5.	Оролцгчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй тогтмол байна.
ТШЗ 21.6	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: Тийм. Incoterms 2020, УБЦТС ТӨХК-ийн агуулах.
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: Tөсөөт өртгийн 0.5 хувьтай тэнцэх төгрөг.</p> <p>Багц 1. Төсөөт өртгийн 0.5 хувьтай тэнцэх төгрөг</p> <p>Багц 2. Төсөөт өртгийн 0.5 хувьтай тэнцэх төгрөг</p> <p>Багц 3. шаардахгүй</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5.	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Шаардахгүй
ТШЗ 26.1.	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2.	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: tender.gov.mn цахим системд нээгдэнэ</p>
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 29.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: Үгүй.
ТШЗ 31.1.	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Шаардахгүй
ТШЗ 32.1	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: Ашиглахгүй

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Зураг, төсөл

Шаардлагатай бол барааны эскиз, зургийг хавсаргана.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

[Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ажлын хувцас

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Ажлын тусгай хувцас. Ерөнхий шаардлага Occupational Safety.Work clothing. General requirement	Байгууллагын стандарт :2013
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------

Нэг. Хамрах ба хэрэглэх хүрээ

1.1 Хамрах хүрээ

“Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн ажилтнуудын ажлын тусгай хувцсанд тавих шаардлага, хувцасны даавуу, өнгө, загвар хийц, дулаалга тогтооход хамаарна.

1.2 Хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээний нийт ажилтнууд, ажлын тусгай хувцас нийлүүлэх үйлдвэр, аж ахуйн нэгж салбарын холбогдох удирдлагууд дагаж мөрдөнө.

2. Норматив ишлэл

Энэ стандартад дараах хүчин төгөлдөр мөрдөж буй стандартуудыг ишлэл болгов.

Иш татсан стандартууд дахин хянацдаж өөрчлөгдвэл хамгийн сүүлийн хувилбарыг мөрдөнө. Үүнд:

- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – Ерөнхий шаардлага
- ISO 105- Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт
- ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох
- ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах
- ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн –Хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгонд кодлох
- ISO-9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын эзэлхүүн, агаарын хэмжээ
- ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт
- MNS ISO 1835 -3:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. 1м²-ийн жин тодорхойлох арга
- MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
- MNS ISO 1835 -5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга
- MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт
- MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга
- MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
- MNS ISO 1835 -13:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Үрэлт тэсвэрлэлт тодорхойлох арга
- MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга

- MNS ISO 4072 : 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга
- MNS ISO 4073:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга
- MNS 4010-2009- Ширхэгтийн бүрэлдэхүүн

3. Тодорхойлолт

3.1 Ажлын тусгай хувцас

Гадны нэг болон хэд хэдэн хүчин зүйл, тааламжгүй сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилгоор тусгайллан хийсэн хувцас.

3.2 Ашиглалтын хугацаа

Хувцсыг хийсэн материалын анхны хийсэн шинж чанарт хадгалалт, ашиглалтын явцаас хамаарч тодорхой хугацааны дараа гарах нэг буюу хэд хэдэн өөрчлөлт

3.3 Ажлын тусгай хувцасны ангилал

Хөдөлмөрийн нөхцлөөс хамаарч ажилтнуудыг ажлын хувцсаар хангагдах ажил мэргэжил, албан тушаалын ангилал, нэрс

3.4 Автовышка

Хүмүүсийг өндөрт ажиллуулах зориулалт бүхий тусгай араг, түүнийг удирдах механизмаар тоноглогдсон автомашин

3.5 Трайллер

20 тн болон түүнээс дээш даацын урт чиргүүл бүхий автомашин

3.6 МТО

Тусгай зориулалтаар тоноглогдсон бүрхүүл бүхий хүнд даацын автомашин

3.7 Синтетик холио

Даавуун дахь синтетик буюу хиймэл ширхэгтийн орцын хувь, хэмжээ

3.8 Вискоз ширхэгт

Целлюлоз ширхэгтийг нийлэгжүүлэн гаргаж авсан ширхэгт

3.9 Байгалийн гаралтай ширхэгт

Байгаль дээр байх амьтны болон ургамлын гаралтай ширхэгт, ноос, ноолуур, хөвөн, олс гэх мэт

3.10 Өнгө материал

Хувцасны хамгийн гадар талын даавуу

3.11 Дотрын материал

Гадуур хувцсыг өмсөх, тайлахад хялбар байлгах, дотор талд өмссөн хувцастай барьцалдахгүй байлгах зориулалт бүхий материал

3.12 Атлас нэхээс

Гөлгөр гадаргуу үүсгэн нэхсэн даавуу (дотрын материал)

3.13 Сарж нэхээс

Диагноль хээ үүсгэн нэхсэн даавуу

3.14 Физик химийн шинж чанар

Хими физикийн үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөх шинж чанар

3.15 Физик механик

Гадны механик үйлчлэлийн нөлөөгөөр өөрчлөгдөх шинж чанар

3.16 Дотрын дотроос салдаг дотор

Тухайн хувцасны дотор талд давхар үе болгон хийсэн дулаалга

3.17 Дотроос салдаг дулаалга

Тухайн хувцасны дотор талд давхар үе болгон хийсэн дулаалга

4.Эргономик

Хөдөлгөөн хийх үед хүний биеийн чөлөөт хөдөлгөөнийг хангах, өмсөх тайлахад хялбар, гадаад орчны нөлөөнөөс хамгаалах зэргийг нэгтгэсэн цогц шаардлага

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.

1.1 Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байна.

1.2 Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байна.

1.3 Хувцасны материал, дулаалга нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан байна.

1.4 Ажлын тусгай хувцас нь өвөл, хавар, намар болон зуны улиралд өмсөх хоёр төрөл байна. Өвлийн улиралд өмсөх хувцас нь -30° С-ээс -40° С хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан дулаалга, доторлогоотой байна.

1.5 Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх

1.6 Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх

1.7 Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх

1.8 Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэнсээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх

1.9 Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

5. Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

5.1. Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх

5.2. Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх

5.3 Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх.

5.4. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй. Хүний биед харшлахгүй байх.

5.5 Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохогүй байна.

5.6. Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх

5.7. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.

5.8 Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцлдохгүй байх

5.9 Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна

5.10 Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. Оруулгын өнгө саарал байна.

6. Ажлын тусгай хувцасны ангилал

Ажлын байр, хөдөлмөрийн нөхцлөөс хамааруулж ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудыг дөрвөн хэсэгт хуваана.

6.1. Ажлын тусгай хувцсаар хангагдах ажилтнуудын мэргэжлийн ангиллыг албан тушаалын онцлогоос хамаарч 1-р хүснэгтэд заасны дагуу байна.

1-р хүснэгт

Д/д	Мэргэжлийн ангилал	Албан тушаалын нэр			
		Удирдлага	ИТА	Монтёр	Бусад
1	Ажлын тусгай хувцсаар хангах III хэсэг	-	-	Ашиглалт, засвар, хэмжилт туршилт, холбооны, монтёрууд, жолооч.	-
2	Ажлын тусгай хувцсаар хангах IV хэсэг /А хэсэг/	-		Засвар тохируу лагын монтёрууд.	-

7. Ажилтнуудыг ажлын тусгай хувцсаар хангах нөхцөл

7.1 I,II,III,IV хэсэгт орсон бүх ажилтнуудын ажлын тусгай хувцас нь загвар хийцийн хувьд ажлын онцлогоос хамаарч харилцан адилгүй байна.

7.2 Хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалж ажлын тусгай хувцасны ашиглалт эдэлгээний хугацаа, дулаалга өөр байна.

8. Ажлын тусгай хувцасны өнгө

8.1 Ажлын байр, албан тушаал, хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалахгүй ажлын тусгай хувцасны I,II,III ангилалд орсон ажилтнуудын хувцасны өнгө ижилхэн, IV ангилалд орсон ажилтнуудын хувьд ялгаатай байна.

8.2 Ажлын тусгай хувцасны өнгийг 2-р хүснэгтэд заасны дагуу байх бөгөөд өвөл ба зуны улиралд өмсөх хувцсанд адил хамаарна.

2-р хүснэгт

Мэргэжлийн ангилал	Өвлийн хувцас			Зуны хувцас		
	Хүрэм		Өмд	Хүрэм		Өмд
	Үндсэн	Нэмэлт /оруулга/		Үндсэн	Нэмэлт /оруулга /	
Ажлын тусгай хувцсаар хангах I хэсэг	Хар хөх	улаан	Хар хөх	Хар хөх	улаан	Хар хөх
Ажлын тусгай хувцсаар хангах II хэсэг	-	-	-	Хар хөх	-	Хар хөх
Ажлын тусгай хувцсаар хангах III хэсэг	Хар хөх	улаан	Хар хөх	Хар хөх	улаан	Хар хөх
Ажлын тусгай хувцсаар хангах IV. "А"хэсэг	-	-	-	Цагаан	-	Цагаан
